



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 30 өдөр

Дугаар А/494

Ховд

Жуух бичгээр шагнах тухай

Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн "Е", аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.8, 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ард иргэдийн эрүүл мэндийг сахин хамгаалах, хөдөө орон нутагт эмнэлгийн тусламж үйлчилгээг хурдан шуурхай, чанартай хүргэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулан Эрүүл мэндийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж буй Дуут сумын Цагаанбургас багийн эмч Л.Энхсайханыг аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр шагнасугай.

2. Аймгийн Засаг даргын Жуух бичгээр шагнагдсан Л.Энхсайханд 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг Дуут сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч эмч / Б.Эрдэнэсолонго /-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

